

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2012 ОНЫ 2 ДУГААР
УЛИРАЛД ИРҮҮЛСЭН ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭНИЙ
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2012.06.30-ны өдрийн байдлаар

НЭГ. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭНИЙ ИРЦИЙН ТАЛААР:

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.1 дэх заалтыг үндэслэн “Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор зарим тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 02 дугаар сарын 28 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д 7 заалт бүхий 2.6 дахь хэсгийг болон гадаад валютын арилжааны мэдээ гаргах хавсралтуудыг тус тус шинээр нэмж, “Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа” эрхлэн явуулдаг банк бус санхүүгийн байгууллага /цаашид ББСБ гэх/-ууд эдгээр хавсралтын дагуу мэдээг дараа сарын 10-ны өдрийн дотор гаргаж, Хороонд ирүүлж байхыг заасан. Үүний дагуу гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудаас гадаад валютын арилжааны мэдээг сар бүр гаргуулан авч, улирлаар нэгтгэн Хорооны удирдлагуудад танилцуулж, нэгтгэлийг товч байдлаар Монголбанкинд хүрүүлж байгаа болно.

Манай улсын хэмжээнд 2012 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэн явуулж буй 198 ББСБ байгаагийн 91 нь буюу 45.96 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 91 ББСБ-ын 37 нь буюу 40.7% нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, 54 нь буюу 59.3% нь энэхүү үйл ажиллагааг банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай давхар эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Тайлант хугацаанд гадаад валютын арилжааны мэдээ ирүүлбэл зохих нийт 91 ББСБ-ын 66 нь ирүүлж, 25 нь ирүүлээгүй бөгөөд мэдээний ирц 72.5 хувь байна.

/Гадаад валютын арилжааны мэдээний ирцийн талаарх мэдээллийг ББСБ тус бүрээр гаргаж, танилцуулгад хавсаргав/.

Мэдээ ирүүлээгүй 25 ББСБ-ын 9 нь тус хугацаанд энэхүү үйл ажиллагааг эрхлэн явуулаагүй бөгөөд цаашид явуулна гэсэн тайлбар бүхий албан бичгийг ирүүлсэн, 16 нь гадаад валютын арилжааны мэдээ болон ямар нэгэн тайлбар бичиг ирүүлээгүй болно.

Гадаад валютын арилжааны мэдээ ирүүлсэн ББСБ-уудын тоонд тус тайлант хугацаанд гадаад валютын арилжаагаар гүйлгээ хийгээгүй тухайгаа албан бичгээр мэдээлсэн 9 ББСБ-ыг оруулж тооцвол мэдээний ирцийн тоо 75 болж, 82.4 хувьтай гарч байна.

Тус хугацаанд “Дэлбээ сакура” ХХК, “Чоно финанс” ХХК зэрэг нийт 2 ХХК-д гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, “Би энд жи ББСБ”

Гадаад валютын арилжааны 2012 оны 2 дугаар улирлын мэдээний нэгтгэл

ХХК, “ОСАБ ББСБ” ХХК, “Түвшин инвест ББСБ” ХХК зэрэг нийт 3 ББСБ-ын гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгожээ.

Мэдээ ирүүлсэн нийт 66 ББСБ нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Мэдээний ирцийг өмнөх улирлуудтай харьцуулан үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	МЭДЭЭ ИРҮҮЛЭХ ББСБ-ЫН ТОО	МЭДЭЭ ИРҮҮЛСЭН ББСБ-ЫН ТОО	МЭДЭЭНИЙ ИРЦ	ӨСӨЛТ, БУУРАЛТ ХУВИАР <small>/өмнөх улирлаас /</small>
1	2010 оны 1 дүгээр улирал	112	31	40.4%	0.0%
2	2010 оны 2 дугаар улирал	110	43	39.0%	-1.4%
3	2010 оны 3 дугаар улирал	109	48	44.0%	5.0%
4	2010 оны 4 дүгээр улирал	95	71	74.7%	30.7%
5	2011 оны 1 дүгээр улирал	93	73	78.5%	3.8%
6	2011 оны 2 дугаар улирал	98	60	61.2%	-17.3%
7	2011 оны 3 дугаар улирал	96	52	54.2%	-7.0%
8	2011 оны 4 дүгээр улирал	92	67	71.7%	17.5%
9	2012 оны 1 дүгээр улирал	91	68	74.7%	3.0%
10	2012 оны 2 дугаар улирал	91	66	72.5%	-2.2%

Дээрх хүснэгтээс үзэхэд тус хугацаанд мэдээ ирүүлсэн ББСБ-ын тоо 2010 оны 4 дүгээр улирлынхаас 5-аар буурч, 2011 оны 2 дугаар улирлынхаас 6-аар өссөн үзүүлэлттэй байна. Мэдээний ирцийг авч үзвэл:

- 2010 оны 1,2,3,4 дүгээр улиралд 39.0% -с 74.7%;
- 2011 оны 1,2,3,4 дүгээр улиралд 54.2% -с 78.5%;
- 2012 оны 1 дүгээр улиралд 74.7% болж 2011 оны 4 дүгээр улирлынхаас 3.0%-иар өссөн;
- 2012 оны 2 дугаар улиралд 72.5% болж өмнөх улирлаас 2.2%-иар буурсан;
- 2011 оны 4 дүгээр улирлынхаас 0.8%-иар өссөн үзүүлэлттэй гарч байна.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо улирлаас улиралд буурч байгаа хэдий ч мэдээний ирц нэмэгдэх хандлагатай байгаа. Тухайлбал:

- Зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 37 ББСБ-аас 35 нь мэдээгээ ирүүлж, 2 нь ирүүлээгүй бөгөөд үүний 1 нь буюу “Дэлбээ сакура ББСБ” ХХК-д Хорооны 2012 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 194 дүгээр тогтоолоор тусгай зөвшөөрөл олгосон тул үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй, “Нарансансар ББСБ” ХХК үйл ажиллагаа явуулсан эсэх тухай баримт бичиг ирүүлээгүй байна.

- Гадаад валютын арилжааны үйл ажиллагааг банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай давхар эрхлэх зөвшөөрөлтэй 54 ББСБ-ын 31 нь мэдээгээ ирүүлж, 9 нь тус тайлант хугацаанд гадаад валютын арилжаагаар гүйлгээ хийгээгүй тухай албан бичгийг ирүүлсэн, 14 нь үйл ажиллагаа явуулсан эсэх талаар огт мэдээлээгүй байна.

Гадаад валютын арилжааны 2012 оны 2 дугаар улирлын мэдээний нэгтгэл

Эндээс үндэслэн үйл ажиллагаа явуулаагүй талаар албан бичгээр мэдээлсэн 9 ББСБ-ыг тус мэдээг ирүүлсэнд оруулан тооцож үзвэл гадаад валютын арилжааны үйл ажиллагааг банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай давхар эрхлэх зөвшөөрөлтэй 54 ББСБ-ын 40 нь буюу 74.1 хувь нь мэдээгээ ирүүлсэн байна гэж үзэхээр байна.

ХОЁР. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА БОЛОН ВАЛЮТЫН ХАНШИЙН ТАЛААР:

Энэхүү нэгтгэлийг ББСБ-уудаас ирүүлсэн гадаад валютын арилжааны мэдээнд үндэслэн хийхдээ тэдгээрийн иргэн, хуулийн этгээдээс худалдан авсан гадаад валютын болон худалдсан гадаад валют бүрийн ханшийг ам.доллар болон Монгол улсын үндэсний валют төгрөгт хөрвүүлсэн дүнгээр тус тус тооцсон болно.

Худалдан авсан болон худалдсан гадаад валютуудыг төгрөгт хөрвүүлсэн дүнгээр тооцож, өмнөх улиралтай харьцуулж үзвэл дараах байдалтай байна.

1. Худалдаж авсан нийт гадаад валют:

д/д	ВАЛЮТЫН НЭР	УЛИРАЛ				
		2010 ОНЫ II улирал	2011 ОНЫ II улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ / +/- / өмнөх үеэс/	2012 ОНЫ II улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ / +/- / өмнөх үеэс/
1	ТӨГРӨГ	42,606,958.7	196,156,917.3	153,549,958.6	771,800,532.7	575,643,615.4
2	АМ. ДОЛЛАРТ ШИЛЖҮҮЛСЭН ДҮНГЭЭР	32,463.5	160,975.7	128,512.2	584,983.2	424,007.50
3	ДУНДАЖ ХАНШ	1312.46	1,218.55	93.91	1,319.36	10081

Худалдаж авсан нийт гадаад валютын төгрөгт хөрвүүлсэн мөнгөн дүнг өмнөх онуудын мөн үеүдтэй харьцуулж үзэхэд:

- 2011 оны 2 дугаар улиралд 2010 оны мөн үеэс 153,549,958.6 мянган төгрөгөөр буюу 4.6 дахин, ам.долларт хөрвүүлсэн дүн 128,512.2 мянган ам.доллараар буюу 4.6 дахин;

- 2012 оны 2 дугаар улиралд 2010 оны мөн үеэс 729,193,574.0 мянган төгрөгөөр буюу 18.1 дахин, ам.долларт хөрвүүлсэн дүн 424,007.5 мянган ам.доллараар буюу 18.0 дахин;

- 2012 оны 2 дугаар улиралд 2011 оны мөн үеийнхээс 575,643,615.4 мянган төгрөгөөр буюу 3.9 дахин, ам.долларт хөрвүүлсэн дүн 424,007.5 мянган ам.доллараар буюу 3.6 дахин тус тус өссөн үзүүлэлттэй гарч байна.

Нэгтгэлд ББСБ-уудын худалдаж авсан нийт гадаад валют тус бүрийн ханшийг ам.долларт хөрвүүлсэн дүнгээр тооцож, ам.долларын дундаж ханшийг тооцож үзэхэд 1,319.36 төгрөг болж байгаа нь:

Гадаадвалютын арилжааны 2012оны 2 дугаар улирлын мэдээний нэгтгэл

- 2010 оны мөн үеийнхээс /1,319.36₮:1,312.46₮/ 6.90 төгрөгөөр буюу 0.52 хувиар;
- 2011 оны мөн үеийнхээс /1,319.36₮:1,218.55₮/ 100.81 төгрөгөөр буюу 7.6 хувиар тус тус өсч;
- 2012 оны 1 дүгээр улирлаас /1,325.70₮:1,346.87/ 21.17 төгрөг буюу 1.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2. Худалдсан нийт гадаад валют:

		<i>/МЯНГАН ТӨГРӨГӨӨР/</i>				
д/ д	ВАЛЮТЫН НЭР	УЛИРАЛ				
		2010 ОНЫ II улирал	2011 ОНЫ II улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ / +/- / өмнөх үеэс/	2012 ОНЫ II улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ / +/- / өмнөх үеэс/
1	ТӨГРӨГ	41,947,511.4	237,093,710.9	195,146,199.5	270,677,108.9	33,583,398.0
2	АМ. ДОЛЛАРТ ШИЛЖҮҮЛСЭН ДҮНГЭЭР	33,566.7	194,131.0	160,564.3	204,176.4	10,045.4
3	ДУНДАЖ ХАНШ	1249.68	1,221.31	-28.37	1,325.70	104.39

Худалдсан нийт гадаад валютын төгрөгт хөрвүүлсэн мөнгөн дүнг өмнөх онуудын мөн үеүдтэй харьцуулж үзэхэд:

- 2011 оны 2 дугаар улиралд 2010 оны мөн үеэс 195,146,199.5 мянган төгрөгөөр буюу 5.6 дахин, ам.долларт хөрвүүлсэн дүн 160,564.3 мянган ам.доллараар буюу 5.8 дахин;

- 2012 оны 2 дугаар улиралд 2010 оны мөн үеэс 228,729,597.5 мянган төгрөг буюу 6.5 дахин, ам.долларт хөрвүүлсэн дүн 170,609.7 мянган ам.доллар буюу 6.1 дахин;

- 2012 оны 2 дугаар улиралд 2011 оны мөн үеэс 33,583,398.0 мянган төгрөг буюу 1.1 дахин, ам.долларт хөрвүүлсэн дүн 10,045.4 мянган ам.доллар буюу 1.1 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Худалдсан валют тус бүрийн ханшийг ам.долларт хөрвүүлж, ам.долларын дундаж ханшийг тооцож үзэхэд 1,325.70 төгрөг болж байгаа нь:

- 2010 оны мөн үеийнхээс /1,325.70₮:1,249.68₮/ 76.02 төгрөг буюу 5.7 хувиар;

- 2011 оны мөн үеийнхээс /1,325.70₮:1,221.31₮/ 104.39 төгрөг буюу 7.9 хувиар өсч;

- 2012 оны 1 дүгээр улирлаас /1,325.70₮:1,357.29₮/ 31.59 төгрөг буюу 2.3 хувиар буурсан үзүүлэлттэй гарч байна.

Энэхүү нэгтгэлээс үзэхэд ББСБ-уудын 2012 оны 2 дугаар улиралд худалдаж авсан нийт гадаад валютын мөнгөн дүн худалдсан нийт гадаад валютын мөнгөн дүнгээс /771,800,532.7₮-

Гадаад валютын арилжааны 2012 оны 2 дугаар улирлын мэдээний нэгтгэл

270,677,108.9₮/ 501,123,423.8 мянган төгрөг буюу 2.8 дахин их, ам.долларт хөрвүүлснээр мөн / 584,983.2\$-204,176.4\$/ 380,806.8 мянган ам.доллар буюу 2.9 дахин их гарч байна.

Тухайлбал “Тунамал алтан зоос ББСБ” ХХК-ийн худалдан авсан гадаад валютын хэмжээ худалдсан гадаад валютаас /386,082,465,15-2,176,046.77/ 383,906,418.4 мянган төгрөгөөр буюу 177.4 дахин их гарч байгаа юм.

Ийнхүү худалдан авсан гадаад валютын мөнгөн дүн худалдсан гадаад валютуудын дүнгээс 501,123,423.8 мянган төгрөгөөр буюу 2.8 дахин их гарч байгаа нь тайлант хугацаанд ББСБ-уудаас мөнгөний зах зээлд нийлүүлэх гадаад валютын нийлүүлэлтийн хэмжээ эрс буурсныг харуулж байна. Гэсэн хэдий ч гадаад валютуудын ам.долларт хөрвүүлсэн ханшийн хэмжээ 2010, 2011 оны мөн үеийнхээс 0.5-7.9 хувиар өссөн боловч 2012 оны 1 дүгээр улирлынхаас 1,6-2,3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эндээс үндэслэн ББСБ-уудын мөнгөний зах зээлд нийлүүлэх гадаад валютын хэмжээ тус зах зээл дэх гадаад валютын эрэлт хэрэгцээнд голчлон нөлөө үзүүлдэггүй болохыг илтгэж байна гэж үзэж байна. Мөн гадаад валютын ханшийн огцом хэлбэлзэлд нөлөөлөх нөлөөлөл бага болохыг гадаад валютын ханшийн хэмжээ өмнөх улирлынхаас буурсан нь илтгэж байна гэж ойлгож байна.

Гадаад валютын арилжааны хэмжээ 2010, 2011 оны мөн үе болон 2012 оны 1 дүгээр улирлынхаас 1.1-18.0 дахин өссөн байгаа нь зах зээл дээр гадаад валютын эрэлт хэрэгцээ өссөнөөр ам.долларын ханш бага багаар чангарч үүнийг даган бусад валютуудын ханш нэмэгдэж иржээ. Энэ нь цаг агаараас хамааралтай буюу улирлын шинж чанартай /тухайлбал уул уурхай, барилга, газар тариалан гэх зэрэг/ үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудын ажил үйлчилгээний цар хүрээ тэлж, үүнийг даган мөнгөний эрэлт хэрэгцээ нэмэгдсэн, гадаадын хөрөнгө оруулагчдаас орж ирэх гадаад валютын санхүүжилт хэмжээ нэмэгдэж, гадаад валютаар төлбөр тооцоо хийдэг дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудын эрэлт хэрэгцээ өссөн зэрэгтэй холбоотой.

2011 оны 12 дугаар сард зах зээл дэх ам.долларын ханш 1,402.0 төгрөгт хүртэл өсч түүнийг даган бусад валютуудын ханш чангарснаар валютын ханшийн зөрүүнээс ашиг олох зорилготой гадаад валютын арилжаа эрхлэгчид гадаад валютыг худалдан авахаас илүү худалдсан.

Харин тус тайлант хугацаанд худалдан авсан гадаад валютын хэмжээ худалдсан валютаас 2.9 дахин их байсан нь Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороонд байрлах Төмөрчний гудамжинд үйл ажиллагаа явуулдаг ББСБ-уудын ажлын байр газарт орсон нь нөлөөлсөн байх талтай. Нэгтгэлээс үзэхэд:

1. Худалдаж авсан нийт валютын 8.2%-ийг хуулийн этгээдээс, 91.8%-ийг иргэдээс худалдан авч;
2. Худалдсан нийт валютын 6.1%-ийг хуулийн этгээдэд, 93.9%-ийг иргэдэд тус тус худалдсан байгаагаас үзэхэд ББСБ-ууд нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаагаар ихэвчлэн иргэдэд үйлчилж ирснийг харуулж байна.

Гадаад валютын арилжааны 2012 оны 2 дугаар улирлын мэдээний нэгтгэл

Тайлант 2 дугаар улиралд ББСБ-ууд гадаад валютын арилжааны үйл ажиллагаагаар давхардсан тоогоор нийт 1,042,477,641.6 мянган төгрөгийн буюу 789,156.6 мянган ам.долларын гүйлгээ хийгдсэн байгаагийн 74.1 хувь нь гадаад валютыг худалдаж авсан гүйлгээ, 25.9 хувь нь гадаад валютыг худалдсан гүйлгээ байна.

Гадаад валютын ялангуяа ам.долларын ханш 2011 оны 10 дугаар сарын 01-нээс 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд нилээд өсч, тус тайлант хугацаанд буурсан боловч гадаад валютыг худалдан авах, худалдах ханшийн зөрүү /1,325.70-1,319.36/ 6.30 төгрөг байсныг боломжийн түвшинд байлаа гэж үзэж байна.

Ам.долларын албан болон зах зээлийн ханшийг 2012 оны 2 дугаар улирлын байдлаар харьцуулж үзвэл Монголбанкнаас зарласан албан ханш /4,5,6 сарын дундаж/-ийн дундаж 1\$=1,325.96₮ байсан бол ББСБ-уудын худалдан авсан болон худалдсан ханшийн дундаж /1,325.70+1,319.36:2/ 1,322.53 төгрөг байв. Энэ нь албан ханшаас 3.43 төгрөгөөр бага дүнтэй гарч байна.

ББСБ-уудын гадаад валютын арилжаанд түгээмэл ордог гадаад валютуудын зах зээл дэх ханшийн өөрчлөлт /хэлбэлзэл/-ийг 2010, 2011 оны жилийн эцэс, 2012 оны 1 дүгээр улирлын байдлаарх үзүүлэлтүүдтэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/ТӨГРӨГӨӨР/

Д/д	ВАЛЮТЫН ТӨРӨЛ		ХАНШИЙН ДУНДАЖ ДҮН			
			2010 оны IV улирал	2011 оны IV улирал	2012 оны I улирал	2012 оны II улирал
1	АНУ доллар	USD	1,270.00	1,329.26	1,352.08	1,322.53
2	Английн фунт	GBP	1,930.96	2,054.99	2,076.05	2,097.24
3	Евро	EUR	1,713.68	1,744.17	1,767.03	1,710.78
4	БНХАУ-ын юань	CNY	188.00	202.35	210.35	209.86
5	БНСУ-ын вон	KRW	1.04	1.35	1.18	1.37
6	ОХУ-ын рубль	RUB	41.20	41.84	44.28	42.86
7	Японы иен	JPY	15.50	18.36	18.36	18.35

Гадаад валютын ханшийн хэлбэлзлийг авч үзүүлвэл дараах байдалтай байна. Үүнд:

/ТӨГРӨГӨӨР/

Д/д	ВАЛЮТЫН ТӨРӨЛ		ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ / ӨСӨЛТ +; БУУРАЛТ -/			
			2010 оны I улирал	2011 оны IV улирал	2012 оны I улирал	2012 оны II улирал
1	АНУ доллар	USD	-	80.83	22.82	-29.55
2	Английн фунт	GBP	-	82.72	21.06	21.19

Гадаад валютын арилжааны 2012 оны 2 дугаар улирлын мэдээний нэгтгэл

3	Евро	EUR	-	10.68	22.86	-56.25
4	БНХАУ-ын юань	CNY	-	10.75	8.00	-0.49
5	БНСУ-ын вон	KRW	-	0.24	-0.17	0.19
6	ОХУ-ын рубль	RUB	-	0.24	2.44	-1.42
7	Японы иен	JPY	-	2.57	-	-0.1

Дээрх хүснэгтээс үзэхэд 2012 оны 2 дугаар улиралд өмнөх улирлынхаас АНУ-ын ам.доллар 29.55 төгрөг, Евро 56.25 төгрөг, Японы иен 0.1 төгрөг, Оросын рубль 1.42 төгрөг, Хятадын юань 0.49 төгрөгөөр тус тус буурч, Английн фунт 21.19 төгрөг, БНСУ-ын вон 0.19 төгрөгөөр тус тус өссөн байна. Үүнээс үндэслэн нийт гадаад валют тус бүрийн хоорондын ханшийн зөрүү харьцангуй тогтуун байсан төдийгүй огцом хэлбэлзэл гараагүй байна.

Гадаад валютын арилжааны мэдээний нэгтгэлээс үзэхэд тайлант хугацаанд нийт / 771,800,532.7₮+270,677,108.9₮/ 1,042,477,641.6 мянган төгрөгийн арилжаа хийсний / 598,005,691.2+94,404,190.7/ 692,409,881.9 мянган төгрөг буюу /453,256.0+71,210.7/ 524,466.7 мянган ам.доллар нь нийт валютын 66.4 хувийг, /19,868,580.0+19,830,645.7/ 39,699,225.7 мянган төгрөг буюу /15,059.3+14,958.6/ 30,017.9 мянган евро нь нийт валютын 3.8 хувийг, /143,811,241.5₮+146,622,965.1₮/ 290,434,206.6 мянган төгрөг буюу /109,001.1+110,600.2/ 219,601.3 мянган юань нийт валютын 27.9 хувийг юань эзэлж байгаа бөгөөд үлдсэн хувийг бусад валют эзэлж байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР